



Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөлийн
2022 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн хурлын
08/2/22 тоот тогтоолын *З...* хавсралт

МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТИЙН ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь салбарын аливаа удирдах ажилтан, мэргэшсэн мэргэжилтэн, мэргэжилтнүүдийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээд, холбогдох төрийн байгууллагуудын гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, заавар, зөвлөмжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхдээ энэхүү журмыг баримтална.

ХОЁР. ЁС ЗҮЙН ХОРОО

2.1. “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам” –ын 2 дугаар зүйлийн 2.2.7 дахь заалтын дагуу ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус ёс зүйн хороог Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөлийн \МГХНЗ\ дэргэд байгуулан ажиллана.

2.2. Ёс зүйн хороог МГХНЗ –ийн хурлын шийдвэрээр 5 –аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, МГХНЗ –ийн даргын тушаалаар ёс зүйн хорооны даргыг томилж, тус хорооны бүрэлдэхүүнийг (нарийн бичгийн дарга, гишүүд) батална.

2.3. Ёс зүйн хороог бүрдүүлэх, түүний даргыг томилоходоо МГХНЗ –ийн хурлаар нэр дэвшүүлэн нууцаар санал хурааж дийлэнх олонхын санал авсан нэр дэвшигчийг оруулах ба түүний бүрэлдэхүүнд бусад төрийн бус байгууллагын гишүүн болон иргэнийг оролцуулж болно.

2.4. Ёс зүйн хороо хурлаараа нарийн бичгийн даргыг томилж МГХНЗ –д уламжлах ба МГХНЗ-ийн даргын тушаалаар батламжлан ажлын үр дүнгээс хамааруулан зарим сард урамшуулал олгохын зэрэгцээ шаардагдах бичиг хэргийн зардлыг шийдэж байна.

2.5. Ёс зүйн хороо нь гомдол, мэдээллийг холбогдох дүрэм, журмынхаа дагуу хянан шийдвэрлэхдээ мэргэжлийн холбоодын ба төрийн байгууллагаас авсан мэргэжлийн боловсон хүчний судалгаа мэдээлэлд тулгуурлан тухайн чиглэлээр ажилласан туршлагатай болон мэргэшсэн 3 хүртэлх мэргэжилтийг татан оролцуулж мэргэжлийн дүгнэлт гаргуулна. Ёс зүйн хороо нь хэлэлцсэн мэргэжилтийн ёс зүйн зөрчлийн талаарх дүгнэлтээ МГХНЗ-ийн даргад уламжилна.

2.6. Гомдол, мэдээлэл гаргасан этгээд ёс зүйн хорооноос шаардсан анхдагч баримт, нотолгоог гаргаж өгөлгүй хуанлийн 30 хоног өнгөрвөл хүчингүйд тооцож дүгнэлт үйлдэн МГХНЗ –ийн даргад уламжилна.

2.7. Ёс зүйн хороо нь дараах эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.7.1. Мэргэшсэн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах,

2.7.2. Гомдол, мэдээлэлд холбогдсон мэргэшсэн мэргэжилтэн, түүний харьяалагдах байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах, түүний үндсэн дээр ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаар дүгнэлт гаргах,

2.7.3. Гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах,

2.7.4. Гомдол, мэдээллийг шалгасан тухай дүнг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхын саналаар мэргэжилтний ёс зүйн зөрчлийн талаар дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлт нь аливаа албан тушаалтны болон бусдын нөлөөлөлд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн байх,

2.7.5. Ёс зүйн хороо нь өөрийн гаргасан шийдвэр, дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

2.7.6. Агентлагууд болон ЭБМЗ –ийн салбар хуралдаануудаас салбарын мэргэшсэн мэргэжилтэн, мэргэжилтнүүдийн оролцоо, хандлага, чадамж, ажлын үр дүнгийн мэдээллийг авах,

2.7.7. Шинжээчээр ажиллах, төсөл хөтөлбөр удирдах боломжтой мэргэшсэн мэргэжилтнүүдэд санал өгөх,

2.8. Ёс зүйн хороо нь тайлан мэдээгээ бүтэн жилээр гаргаж дараа оны 1 дүгээр сарын 15 дотор МГХНЗ –д ирүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хугацааны дундуур явцын тайлан, мэдээлэл, шаардлага, хүсэлтийг албан бичгээр, цахимаар илгээнэ.

2.9. МГХНЗ –ийн гишүүн болон гишүүн бус салбарын холбоодод тухайн холбооны гишүүн мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээлэл мөн хамаарах бөгөөд шийтгэврийн хуудаснаа овоглогдон явах болно.

2.10. МГХНЗ нь Ёс зүйн хорооны дүгнэлтийг шийдвэрлэхдээ “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам” –ын 3 дугаар зүйлийн 3.8.5 дахь заалтад тусгагдсан байгууллагуудад танилцуулж, саналыг авсан байна.

2.11. МГХНЗ нь төрийн захиргааны төв байгууллага болон эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд мэргэшсэн мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрмийн болон хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, заавар, зөвлөмжийн хэрэгжилт ба ёс зүйн хэм хэмжээний зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таниулан сурталчлах зэрэг үндсэн үүргийнх нь дагуу ёс зүйн хорооны дарга ба гишүүдийн нэрсийг хүргүүлэн салбар хуралдаанууд ба УТХ –ийн төслүүдийн шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах ажиллагаанд ажиглагчаар оролцуулах тухай хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

2.12. Ёс зүйн хорооноос гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн гомдол, хүсэлт гаргасан байгууллага, хувь хүн хариуцах ба буруутай этгээдээр зардлыг гаргуулах ажлыг МГХНЗ хариуцна.

2.13. “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам” –ын 5.3 дахь заалт, Геологийн салбарын мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний 5.2.6 дахь заалт, энэхүү журмын 1.1 дахь заалтын зорилгыг хэрэгжүүлэх үүднээс олон нийтийн цахим сүлжээнд МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХУУДАС үүсгэн олон нийтэд таниулан, сурталчилж, мэдээлнэ.

ГУРАВ. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДҮГНЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ

3.1. Ёс зүйн хороо нь дүгнэлтээ МГХНЗ –ийн даргад танилцуулна.

3.2. Аливаа удирдах ажилтан, мэргэшсэн мэргэжилтэн, мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргасныг тогтоож, сахилгын шийтгэл ноогдуулахаар гаргасан Ёс зүйн хорооны дүгнэлт болон бусад холбогдох байгууллагуудын шийдвэрийг үндэслэн МГХНЗ –ийн дарга шийтгэл оногдуулах талаар тушаал гаргаж шийдвэрлэх бөгөөд гаргасан шийдвэрээ төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногийн дотор уламжилна.

3.3. МГХНЗ –ийн дарга нь Ёс зүйн хорооны дүгнэлтийг хянаж үзээд, дараах үндэслэлээр дахин шалгуулахаар Ёс зүйн хороонд буцаах шийдвэр гаргаж болно. Үүнд:

3.3.1. Ёс зүйн зөрчил гаргасны нотолгоо, баримт бичгийн бүрдэл хангагдаагүй,

3.3.2. Холбогдох нотолгоо, баримт бичиг, материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан,

3.4. Мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээлэл үндэслэлгүй болохыг тогтоосон Ёс зүйн хорооны дүгнэлтийг МГХНЗ –ийн дарга зүйтэй гэж үзсэн бол шийдвэрийг холбогдох талуудад мэдэгдэнэ.

ДОРӨВ. МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

4.1. МГХНЗ –ийн Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн МГХНЗ –ийн дарга тухайн мэргэшсэн мэргэжилтэнд мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3 –д заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ноогдуулах тухай шийдвэр гаргана.

4.2. Буруутай мэргэшсэн мэргэжилтнийг батлан дааж тодорхойлолт /ММЗ – ийн ажиллах журмын 2.47/ гаргагч нь мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн дүрмийн 3.3.1 – д заагдсан шийтгэл хүлээнэ.

4.3. Ёс зүйн зөрчил нь гэмт хэргийн болон авлигын шинжтэй бол харьяаллын дагуу шалгуулахаар Анхан шатны Шүүх, Прокурорын байгууллагад шилжүүлнэ. Мэргэшсэн мэргэжилтэн нь сахилгын шийтгэл ноогдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо гаргаж болно.

ТАВ. БУСАД

5.1. Ёс зүйн хорооноос энэхүү журмын 2.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд гаргасан зардал, урамшууллыг “мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн ажиллах журам” – ын 1.6 –д заагдсан сургалтын төлбөрөөс гаргана.

5.2. Ёс зүйн хорооноос энэхүү журмын 2.7.2 дахь заалтыг хэрэгжүүлэхэд гаргасан зардлыг “мэргэшсэн мэргэжилтний зөвлөлийн ажиллах журам” – ын 2.10 –д заасан буруутай этгээдээр гаргуулна.

5.3. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.